


БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баянговь сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/127/НА-СТА-ТШЗ

<p>Баянхонгор 2022 он Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a> Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866      Цахим хаяг: <a href="mailto:bunchinsurenn@audit.gov.mn">bunchinsurenn@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Төлбөрийн акт .....	16
4.2 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/145

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянговь сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянговь сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

d:\бичиг хэрэг 2020-албан тоот а4.docx

• 005020628

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains the Mongolian text "МОНГОЛЫН АУДИТ АГУУН" (Mongolian Audit Agency) and "АДБОУС" (Audit Agency of the State). The signature is written in a cursive style, starting from the left and extending across the stamp.

Б.МӨНХБАТ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>70,036,795.00</b>	<b>87,033,454.08</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,800,000.00</b>	<b>744,889.08</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	722,925.08
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>1,800,000.00</b>	<b>21,964.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	1,800,000.00	21,964.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>68,236,795.00</b>	<b>86,288,565.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>4,000,000.00</b>	<b>6,870,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	4,000,000.00	6,870,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>43,922,795.00</b>	<b>64,157,065.00</b>
35410	Бичиг хэргийн материал	3,103,175.00	2,819,175.00
35420	Аж ахуйн материал	4,662,100.00	4,662,100.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	40,000.00
35470	Бусад хангамжийн материал	36,157,520.00	56,635,790.00
35600	Мал амьтад	20,314,000.00	15,261,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,854,815,789.49</b>	<b>1,702,858,404.40</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,854,815,789.49</b>	<b>1,702,858,404.40</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,829,947,789.49</b>	<b>1,677,990,404.40</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,713,762,777.34	1,770,565,477.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	-416,341,780.76	-567,212,096.25
39203	Авто-тээврийн хэрэгсэл	221,150,000.00	276,050,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-97,775,000.38	-139,416,667.02
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	214,242,368.00	223,473,868.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-98,491,774.11	-154,633,225.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,583,190.00	59,583,190.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,080,299.67	-39,268,436.84
39209	Зам, гүүрийн байгууламж	199,800,000.00	209,800,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-50,616,000.00	-58,608,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	229,493,158.20	243,882,958.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-112,095,849.13	-146,543,663.45
39217	Ном	317,000.00	317,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>24,868,000.00</b>	<b>24,868,000.00</b>
39301	Програм хангамж	850,000.00	850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-850,000.00	-850,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	24,868,000.00	24,868,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,924,852,584.49</b>	<b>1,789,891,858.48</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>350,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>350,000.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>00.00</b>	<b>350,000.00</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>00.00</b>	<b>350,000.00</b>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	350,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,924,852,584.49</b>	<b>1,789,541,858.48</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,924,852,584.49</b>	<b>1,789,541,858.48</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	513,984,711.00	513,984,711.00
51101	Өмч: - төрийн	513,984,711.00	513,984,711.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,218,964,919.70</b>	<b>1,083,654,193.69</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,218,964,919.70	1,218,964,919.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-135,310,726.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	191,902,953.79	191,902,953.79
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,924,852,584.49</b>	<b>1,789,891,858.48</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>582,645,889.00</b>	<b>667,704,259.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>168,879,876.00</b>	<b>182,614,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>168,879,876.00</b>	<b>182,614,800.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	168,879,876.00	39,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,190,000.00	39,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	167,689,876.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	00.00	136,474,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	00.00	46,101,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>413,766,013.00</b>	<b>485,089,459.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,212,919.00</b>	<b>16,569,559.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,212,919.00	16,569,559.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>406,553,094.00</b>	<b>468,519,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	406,553,094.00	468,519,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>675,211,165.57</b>	<b>803,014,985.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>675,211,165.57</b>	<b>803,014,985.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>640,727,367.65</b>	<b>758,814,613.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>228,698,089.00</b>	<b>228,106,160.45</b>
210101	Үндсэн цалин	228,698,089.00	228,106,160.45
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,585,162.08</b>	<b>30,582,774.26</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,517,871.65	21,419,874.86
210202	Тэтгэмжийн даатгал	6,141,198.37	2,290,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,257,977.90	1,832,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	316,301.15	458,199.40
210205	Эрүүл мэндийн даатгал	3,351,813.02	4,581,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,235,204.00</b>	<b>39,467,305.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,141,633.00	9,116,569.00
210302	Түлш, халаалт	34,093,571.00	30,350,736.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,024,565.00</b>	<b>96,984,782.00</b>
210401	Бичиг хэрэг	6,255,650.00	4,931,600.00
210402	Тээвэр, шатахуун	23,731,715.00	31,399,512.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	956,700.00	00.00
210404	Ном, хэвлэл	00.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	9,734,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,960,500.00	36,872,090.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	13,947,580.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>484,000.00</b>	<b>500,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	484,000.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>720,000.00</b>	<b>13,559,485.00</b>
210604	Урсгал засвар	720,000.00	13,559,485.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,945,000.00</b>	<b>3,531,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,945,000.00	3,531,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,026,778.00</b>	<b>12,439,421.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,136,778.00	6,711,814.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	799,250.00

**Баянговь сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	520,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	349,875.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	890,000.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	00.00	193,782.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>285,008,569.57</b>	<b>333,643,685.09</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,903,200.00	34,362,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	278,005,369.57	299,281,385.09
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,483,797.92</b>	<b>44,200,371.71</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,362,700.00</b>	<b>41,566,084.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,812,700.00	40,486,084.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,550,000.00	1,080,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>8,121,097.92</b>	<b>2,634,287.71</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,121,097.92	2,601,957.21
213404	Хөрөнгийн	00.00	32,330.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-92,565,276.57</b>	<b>-135,310,726.01</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>7,760,500.00</b>	<b>00.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	7,760,500.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-7,760,500.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-100,325,776.57</b>	<b>-135,310,726.01</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>414,956,013.00</b>	<b>486,929,059.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,190,000.00</b>	<b>1,839,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,190,000.00</b>	<b>1,839,600.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,190,000.00</b>	<b>1,839,600.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,190,000.00	1,839,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>413,766,013.00</b>	<b>485,089,459.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,212,919.00</b>	<b>16,569,559.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,212,919.00	16,569,559.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>406,553,094.00</b>	<b>468,519,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	406,553,094.00	468,519,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>403,816,013.00</b>	<b>476,079,059.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>403,816,013.00</b>	<b>476,079,059.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>369,332,215.08</b>	<b>431,878,687.29</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>229,032,751.08</b>	<b>228,136,960.39</b>
210101	Үндсэн цалин	191,952,851.08	185,804,506.00
210102	Нэмэгдэл	31,264,300.00	36,439,254.07
210105	Гэрээт ажлын хөлс	5,815,600.00	5,893,200.32
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,256,500.00</b>	<b>30,924,899.40</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,288,600.00	21,762,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,336,300.00	2,290,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,888,400.00	1,832,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	457,600.00	458,199.40
210205	Эрүүл мэндийн даатгал	4,485,600.00	4,581,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,216,371.00</b>	<b>35,909,700.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,122,800.00	7,500,000.00
210302	Түлш, халаалт	34,093,571.00	28,409,700.00

**Баянговь сумын ЗДТ-ын 2021 оны санхүүгийн тайлан  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,718,850.00</b>	<b>41,997,100.00</b>
210401	Бичиг хэрэг	5,143,150.00	3,471,600.00
210402	Тээвэр, шатахуун	19,600,000.00	21,095,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	956,700.00	00.00
210404	Ном, хэвлэл	00.00	670,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	15,360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,659,000.00	1,400,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>500,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,700,000.00</b>	<b>4,339,900.00</b>
210604	Урсгал засвар	2,700,000.00	4,339,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,945,000.00</b>	<b>3,531,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,945,000.00	3,531,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,922,643.00</b>	<b>20,692,133.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,463,431.00	15,197,812.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	799,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	522,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	139,875.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,209,212.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	00.00	168,696.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,540,100.00</b>	<b>65,846,994.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,440,100.00	65,846,994.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,483,797.92</b>	<b>44,200,371.71</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,362,700.00</b>	<b>41,566,084.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,812,700.00	39,067,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,550,000.00	2,498,184.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>8,121,097.92</b>	<b>2,634,287.71</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,121,097.92	2,601,957.21
213404	Хөрөнгийн	00.00	32,330.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>11,140,000.00</b>	<b>10,850,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>11,140,000.00</b>	<b>10,850,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,140,000.00</b>	<b>10,850,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>11,140,000.00</b>	<b>10,850,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,140,000.00	10,850,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-11,140,000.00</b>	<b>-10,850,000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	513,984,711.00	191,902,953.79	1,319,290,696.27	2,025,178,361.06
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	513,984,711.00	191,902,953.79	1,319,290,696.27	2,025,178,361.06
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-100,325,776.57	-100,325,776.57
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	513,984,711.00	191,902,953.79	1,218,964,919.70	1,924,852,584.49
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	513,984,711.00	191,902,953.79	1,218,964,919.70	1,924,852,584.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	513,984,711.00	191,902,953.79	1,218,964,919.70	1,924,852,584.49
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-135,310,726.01	-135,310,726.01
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	513,984,711.00	191,902,953.79	1,083,654,193.69	1,789,541,858.48

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

мянган төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	469,519,900.00	467,757,542.79	1,762,357.21	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	469,519,900.00	467,757,542.79	1,762,357.21	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,733,800.00	426,191,458.79	1,542,341.21	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,073,900.00	228,136,960.39	936,939.61	99.6
210101	Үндсэн цалин	186,456,200.00	185,804,506.00	651,694.00	99.7
210102	Нэмэгдэл	37,009,200.00	36,439,254.07	569,945.93	98.5
210105	Гэрээт ажлын хөлс	5,608,500.00	5,893,200.32	-284,700.32	105.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,924,900.00	30,924,899.40	0.60	100.0
210201	Тэтгэврийн даатгал	21,762,000.00	21,762,000.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,290,700.00	2,290,700.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,832,600.00	1,832,600.00	0.00	100.0

**Баянговь сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210204	Ажилгүйдлийн даатгал	458,200.00	458,199.40	0.60	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,581,400.00	4,581,400.00	0.00	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,909,700.00</b>	<b>35,909,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,500,000.00	7,500,000.00	0.00	100.0
210302	Түлш, халаалт	28,409,700.00	28,409,700.00	0.00	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,997,900.00</b>	<b>41,997,100.00</b>	<b>800.00</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	3,371,400.00	3,471,600.00	-100,200.00	103.0
210402	Тээвэр, шатахуун	21,095,500.00	21,095,500.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	771,000.00	670,000.00	101,000.00	86.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,360,000.00	15,360,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,400,000.00	1,400,000.00	0.00	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,189,900.00</b>	<b>13,189,900.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,850,000.00	6,850,000.00	0.00	100.0
210602	Тавилга	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	4,339,900.00	4,339,900.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,531,000.00</b>	<b>3,531,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	3,531,000.00	3,531,000.00	0.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,216,500.00</b>	<b>6,064,059.00</b>	<b>152,441.00</b>	<b>97.5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600,000.00	569,738.00	30,262.00	95.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	800,000.00	799,250.00	750.00	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	522,500.00	522,500.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	139,875.00	110,125.00	56.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	180,000.00	168,696.00	11,304.00	93.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>66,390,000.00</b>	<b>65,937,840.00</b>	<b>452,160.00</b>	<b>99.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,990,000.00	65,937,840.00	52,160.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	00.00	400,000.00	0.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>41786100.00</b>	<b>41566084.00</b>	<b>220,016.00</b>	<b>99.5</b>

**Баянговь сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>41,786,100.00</b>	<b>41,566,084.00</b>	<b>220,016.00</b>	<b>99.5</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,067,900.00	39,067,900.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,718,200.00	2,498,184.00	220,016.00	91.9
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>469,519,900.00</b>	<b>467,757,542.79</b>	<b>1,762,357.21</b>	<b>99.6</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>468,519,900.00</b>	<b>465,917,942.79</b>	<b>2,601,957.21</b>	<b>99.4</b>
132001	Орон нутгийн төсвөөс	468,519,900.00	465,917,942.79	2,601,957.21	99.4
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,839,600.00</b>	<b>-839,600.00</b>	<b>184.0</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,839,600.00	-839,600.00	184.0
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>24</b>	<b>20</b>	<b>4</b>	<b>83.3</b>
620001	Удирдах ажилтан	8	8	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	9	5	4	55.6
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>24</b>	<b>20</b>	<b>4</b>	<b>83.3</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	5	4	55.6
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	0	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,790,571.0</b>	<b>16,532,228.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,790,571.0</b>	<b>16,532,228.5</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,790,571.0</b>	<b>16,532,228.5</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,790,571.0</b>	<b>14,623,074.5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,790,571.0	14,623,074.5
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>-</b>	<b>1,909,154.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,909,154.0
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>6,790,571.0</b>	<b>16,532,228.5</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>6,790,571.0</b>	<b>16,532,228.5</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,790,571.0	16,532,228.5

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянговь сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянговь сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021-ны 12 дүгээр сарын 20 өдрийн 141 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянговь сумын ЗДТГ-ын дарга Д.Отгонжаргал, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Э.Мөрөндалай нар зурсан байна.

#### 3.2.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянговь сумын ЗДТГ нь "Орчин үеийн тэргүүний дэвшилтэт технологийг ажил албандаа нэвтрүүлж өндөр боловсрол мэргэжилтэй чадварлаг төрийн албаны бүтцээр төрийн үйлчилгээг байгууллага иргэдэд түргэн, шуурхай, хүртээмжтэй, чанартай, хүргэхэд оршино" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж иржээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянговь сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянговь сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 682,971.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,829.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,780.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 5,621.1 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянговь сумын ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,789,891.9 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 134,960.7 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	70,036.8	87,033.5	16,996.7
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,800.0	744.9	(1,055.1)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	68,236.8	86,288.6	18,051.8
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,854,815.8	1,702,858.4	(151,957.4)
Үндсэн хөрөнгө	2,662,066.5	2,809,390.5	147,324.0
Хуримтлагдсан элэгдэл	(807,250.7)	(1,106,532.1)	(299,281.4)
<b>Нийт хөрөнгө</b>	1,924,852.6	1,789,891.9	(134,960.7)
Өр төлбөр	-	350.0	350.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,924,852.6	1,789,541.9	(135,310.7)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1,924,852.6	1,789,891.9	(134,960.7)

/Эх сурвалж Баянговь сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангаас/

Авлагын дансны 744.9 мянган төгрөг болж 1,055.1 мянган төгрөгөөр буурсан байна. Авлагын үлдэгдэлд цалингийн урьдчилгааны 480.0 мянга, НДШ-ийн авлага 145.9 мянга, ХАОАТ-ын 97.0 мянга, халаалтын зардлын 21.9 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 86,288.6 мянган төгрөг болж 18,051.8 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын шилжүүлэг 2,870.0 мянга, сэлбэг хэрэгсэл 40.0 мянга, бусад хангамжийн материал 20,478.2 тус тус өссөнтэй холбоотой байна.

Бараа материалд 46,101.2 мянган төгрөгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан орлогод сумын Орон нутгийн хөгжлийн сан, сум дундын ойн ангиас өвс тэжээл үнэ 27,970.0 мянга, Дэлхийн Зөн олон улсын байгууллагаас гэрэлт самбар, ус буцалгагч 2,066.0 мянга, ухаалаг Аудитын код БНА-2022/127/НА-СТА-ТШЗ

худаг төслөөр худгийн багаж хэрэгсэл 9,700.0 мянга, ГБХЗХГ-аас хангамжийн материал 1,365.2 мянган төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,809,390.5 мянган төгрөг болж 147,324.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 10,850.0, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 46,802.7 мянган төгрөгийн барилга байгууламж, 54,900.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, аймгийн ХХААГ-аас 2,381.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 12,389.8 мянган төгрөгийн шилэн кабелийг төлбөргүй шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,789,541.9 мянган төгрөг болж 135,310.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 135,310.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг 464,350.0 санхүүжүүлэх эх үүсвэр зарлагыг 464,350.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 47,458.1 мянган төгрөгөөр бууруулж 416,891.9 мянган төгрөгөөр анх батлагдсан ба төсвийн тодотголоор 52,628.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн хангамж бараа материалын зардал, эд хогшил авах зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг нэмэгдүүлэн баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 469,519.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 468,519.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 468,519.9 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 1,839.6 мянган төгрөгийн орлого орж, урсгал үйл ажиллагаанд 467,757.5 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсвийн санхүүжилтээс 2,601.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 467,757.5 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 936.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 152.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 452.2 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 220.0 мянган төгрөг тус тус хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 16,569.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 16,532.2 мянган төгрөг зарцуулж 37.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

д/д	Зориулалт	Орлого	Зарцуулсан	үлдэгдэл
1	Хандив	300.0	300.0	-
2	Аймгийн Засаг даргын захирамж А/44 өвөлжилт хүндэрсэн сумдад тусламж	4,432.4	4,400.0	32.4
3	Усны төлбөр/Чандмань ХХК/	4,470.0	4,465.1	4.9
4	Цахим тендерийн хураамж	280.0	280.0	-
5	Статистик/Хагас жилийн мал тооллогын зардал	987.2	987.2	0.0
6	Хамтарсан багийн санхүүжилт	2,300.0	2,300.0	-
7	Аймгийн Засаг даргын Захирамж А/573 Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьд сэргийлэх зардал	300.0	300.0	-
8	Нөхөн сэргээлтийн барьцаа	3,500.0	3,500.0	-
	<b>Нийт дүн</b>	<b>16,569.6</b>	<b>16,532.2</b>	<b>37.3</b>

Эх сурвалж: Баянговь сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 74 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 86 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор Н.Бүнчинсүрэн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 803,014.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 127,803.8 мянган төгрөгөөр буюу 18.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж, бараа материалын зардал, нормативд зардал, урсгал засвар, эд хогшил, урсгал засварын зардал, дотоод албан томилолтын зардал, бараа үйлчилгээний зардал, урсгал шилжүүлгийн зардал өмнөх оноос өсөж, цалин, хөлс нэмэгдэл урамшил, байр ашиглалттай холбоотой зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 547,922.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 113 мэдээллийг хугацаанд мэдээлж 31 мэдээлэл хугацаа хоцроосон, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 4 улирал, бүтэн жилээр, Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан Бүтэн жилээр, Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан Бүтэн жилээр, Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр) гэсэн 5 мэдээллийг мэдээлээгүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	0	5	4	2
2	Хагас жил	4	4	3	1		
3	Улирал бүр	1	4	3	0	1	
4	Сар бүр	3	36	31	5		
5	Тухай бүр	8	96	76	20		
	Нийт	27	151	113	31	5	2

Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 мөнгөн гүйлгээний 149,529.7 мянга, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 37,244.4 мянган төгрөгийн 6 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

### **3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Тайлант оны эхэнд 416,891.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан ба тодотголоор 52,628.0 мянган төгрөгийн нэмэгдүүлж оны эцэст 469,519.9 мянган төгрөгийн зарцуулахаас гүйцэтгэлээр 467,757.5 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст орон нутгийн төсвийн санхүүжилтээс 2,601.9 мянга, туслах үйл ажиллагааны давсан орлогоос 839.6 мянган төгрөг буюу төсвийн 0.6 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 36,568.6 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 341.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 35,909.7 мянган төгрөгийг зарцуулсан нь ЗГ-ын 43 тогтоолын 1.8 дах заалттай нийцэхгүй байна.

### **3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд сумын ЗДТГ-аас шатахууны худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “зөрчилгүй” санал дүгнэлт авсан ба аудитаар нийт 3500.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 2000.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1,500.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг Баянговь сумын ЗДТГ-ын 2021.06.16-ний 78 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар 191,569.5 мянган төгрөгийн 4 зөрчил илэрч 724.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 480.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, алдаа зөрчил арилгах, 190,364.8 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй 2 зөвлөмжийг хүргүүллээ.

### **4.1 Албан шаардлага**

Баянговь сумын ЗДТГ-ын дарга Д.Отгонжаргал нь 2017 оны 04 дүгээр 03-ны өдрийн 11 дүгээр тушаалаар санхүүгийн албаны дарга Б.Энхжаргалыг ажлаас халсан ба иргэн Б.Энхжаргал нь Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандаж 2019.01.15-ны өдрийн 121/ШШ2019/001/3 дугаар шийдвэрээр ажилд эгүүлэн тогтоолгон, ажил байсан хугацааны цалин, НДШ-ийг нөхөн төлүүлэх шийдвэр гарсан байна.

Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.01.15-ны өдрийн 121/ШШ2019/001/3 дугаартай шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхээр Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021.09.30-ны өдрийн 1/771 тоот мэдэгдэл ирсний дагуу тус байгууллагын нягтлан бодогч байсан Б.Энхжаргалын ажилгүй байсан 2017.04.03-2018.05.29-нийг хүртэлх хугацааны ажил олгогчоос төлөх 724.7 мянган төгрөгийг тайланд оны нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлсөн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас төрд учруулсан 724.7 мянган төгрөгийн хохирлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авах албан шаардлага өгөв.

### **4.2 Төлбөрийн акт**

1. Тайлант оны эцэст 744.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдлээс ажиллагсад олгосон цалингийн урьдчилгааны үлдэгдэл 480.0 мянган төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-т “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Цалингийн урьдчилгааны 480.0 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнаас суутгаж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тус байгууллага нь 2021 онд нийт 547,922.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 113 мэдээллийг хугацаанд

мэдээлж 31 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 мэдээлэл мэдээлээгүй байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 мөнгөн гүйлгээний 149,529.7 мянга, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 37,244.4 мянган төгрөгийн 6 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээллийг хугацаанд үнэн зөв мэдээлж байх.

2. Тайлант хугацаанд 469,519.9 мянган төгрөгийн төсөв батлагдсан ба гүйцэтгэлээр 467,757.5 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст орон нутгийн төсвийн санхүүжилтээс 2,601.9 мянга, туслах үйл ажиллагааны давсан орлогоос 839.6 мянган төгрөг буюу төсвийн 0.6 хувийг буцаан төвлөрүүлжээ.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсөв 35,909.7 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан нь төсвийн хэмнэлтийн талаар авах арга зарим арга хэмжээний тухай тогтоолын дагуу 3,590.7 мянган төгрөгийг хэмнэх боломжийг алдсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.1-т “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.8-т “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн хэмнэлтийн горимыг баримтлан ажиллаж үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх, өглөг, авлага үүсгэхгүй байх зөвлөмжийг хүргүүлж байна.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянговь сумын ЗДТГ	5	191,569.5			1	480.0	1	724.7	2	190,364.8

оОо